

ИХЭТУАНИЙ БОСЛОГО
(1898-1901)
(80 жилийн ойд нь)

Н. Алтанцэцэг

XIX зууны дунд үед капиталист улсууд дэлхийг колончилох явдлаа идэвхжүүлсний улмаас Манж гүрний ноёрхолд байсан феодалын нийгэмт Хятад орон дэлхийн капиталист зах зээлд татагдан орох болов.

Манжийн эзэнт гүрний ноёрхол, феодалын нийгмийг эсэргүүцсэн олон сая тариачны хөдөлгөөн (Тайпины хөдөлгөөн 1851-1864) хятад даяар дэгдсэн бөгөөд түүнд хотын ядуучууд, худалдаачдын бослогууд (Шанхай, Амой) бас хятад биш ард түмэн Синьзян-уйгур, Дунгааны ард түмний бослого хамрагдаж цөмөөрөө феодалын ёсыг халахын төлөө тэмцлийг өрнүүлсэн байна. Тухайн үед Манж гүрний засгийн газар хятадын тариачид ядуучуудын тэмцлийг цэрэг зэвсгийн хүчээр хайр найргүй дарж байсан нь гүрний дотоодын ангийн тэмцлийг улам хурцатгаж, улс орны үйлдвэрлэх хүчинд муугаар нөлөөлж байв.

Дэлхийн капиталист улсууд Манж гүрний төв хятад нутаг руу оруулах бараа таваараа ихэсгэж байсан нь хятад орны аж үйлдвэр, үндэсний гар урлалын хөгжилд ноцтой саад учруулж байв. Гадаадын капиталист улсууд Хятадаас торго, цай, хөвөн, үр тариаг их хэмжээгээр гадагш нь тээвэрлэдэг болсон нь хятадын хөдөө аж ахуйг дэлхийн зах зээлтэй нягт холбох болов. Чухам ингэж Манжийн эзэмшил дэх Хятад орон капиталист ертөнцийн газар тариалан, түүхий эдийн бааз нь болж хувирлаа.

1870-80 оны үед капиталист улсууд Манж гүрний ноёрхолд их бага хэмжээгээр хамрагдаж байсан түүний хөрш зэргэлдээх орнуудыг эзлэн авсан байв. XIX зууны эцсээр дотоодын хямралд бүрэн автагдсан Манж гүрний засгийн газар гадаадын капиталист улсуудаас улс орноо хамгаалах чадалгүй байв. Капиталист улсууд Манж гүрэн буюу «Тэнгэрийн доорхи эзэнт улсын» ноёрхол дахь хятад орныг хуваан эзэмшихийн тулд өөр хоорондоо өрсөлдөх болов.

1894-1895 оны «Хятад-японы дайнд» Манж гүрэн ялагдал хүлээсэн нь капиталист улсуудаас түүнийг эзлэн түрэмгийлэх явууллагаа идэвхжүүлэхэд түлхэц болов. Энэ тухай В. И. Ленин бичихдээ: «...Япон улс үйлдвэрийн үндэстэн болон хувираад, хятадын цагаан хэрмийг цөм цохихыг оролдон, амттайхан хэрчмийг нээхэд Англи, Герман, Франц, Оросын ба Италийн ч капиталистууд нэн даруй зууралдаж авсан юм»¹ гэжээ.

1890 оны дундуур Манжийн ноёрхол дахь Хятад оронд гадаадын капитал улам хүчтэй нэвтэрч ирэв. Энэ үед Манж гүрний засгийн газар гадаадын худалдааны 32 боомт хотыг нээжээ. 1899 онд капиталист улсууд Манж гүрний засгийн газарт 54 сая ф-ст-ийн зээллэг олгожээ. Үүний хариуд гадаадынхан төмөр зам тавих, үйлдвэр завод барих эрх олж авчээ. Төмөр зам үйлдвэрийн газраас орох орлогыг тэд өөрсдөө авдаг.

¹В. И. Ленин. «Хямралаас авах сургамж» В. И. Ленин зохиолууд, 5 дугаар боть, 81—82 дугаар тал.

байв. Мөн эдийн засаг, цэрэг дайны давуу талыг ашиглан газар түрээслэн авч буй нэрийдлээр хятадын газар нутагт суурьшин эзэмших болов.

Гадаадын түрэмгийлэгчид зөвхөн улс төр, эдийн засаг, цэрэг дайны хүрээнд өөрийн эзлэн түрэмгийлэх бодлогоо явуулаад зогсоогүй мөн үзэл суртлын явууллага хийж байв. Үүнийг гардан явуулагчид нь миссионерүүд буюу католиг шашин номлогчид байв. 1890 он гэхэд хятадад 628 европ, 335 хятад христос шашинтан лам байв.¹

Гадаадын капитал Манж гүрний дотоодод гүн нэвтрэх болсон нь хэдийгээр феодалын нийгмийг задруулж байсан боловч империалист гүрнүүд Манжийн ноёрхолд байсан Хятад орныг шатлан хувааж, манжийн тусгаар тогтнолд ноцтой аюул учруулж байлаа.

Капиталист орнуудын эзлэн түрэмгийлэх бодлого нь Манж гүрний олон үндэстэн угсаатан ард түмэн ялангуяа Хятадын өргөн олон ард түмний дургүйцэл төрүүлэх болов. Хятадын феодал ангийн төлөөлөгчид, шэньши, сэхээтнүүдийн дунд ч гэсэн ирээдүйн төлөө санаа зовних явдал үзэгдэж байв. Тэр үеийн либерал сэхээтнүүд Кан Ювэй, Лян Цичао тэргүүтэй реформистүүд Хятадыг «шинэчлэлтийн замаар» капиталист орнуудын түрэмгийллээс аврахыг оролдож байв.

Мөн Манж гүрний засгийн газрын Ган И, Дуань зэрэг хуучныг баримтлагч зарим сайд түшмэд гадаадын гүрнүүдийн эсрэг тэмцэх бодлого баримталж байв. Гэвч тэдний ихэнх нь улс орны төлөө санаа тавихаасаа өөрсдийн ашиг сонирхлыг эрхэмлэн үздэг байв.

Гадаадын гүрнүүдийн түрэмгийлэл нь Манж гүрний доторхи олон үндэстэн угсаатан ард түмнүүдийн дургүйцлийг ихэд хүргэсэн байна. Ялангуяа гадаадын түрэмгийллийг эсэргүүцсэн хятадын ард түмний тэмцэл газар сайгүй явагдаж байсны дотроос умард хятадад гарсан ард түмний тэмцэл чухал байр суурь эзэлдэг. Энэ тэмцэл хятадын түүхэнд «Ихэтуаний бослого» хэмээн алдаршжээ. Энэ бослогын гол төвүүд Шань-дун, Жили мужууд байв. Энэхүү тэмцлийг «Ихэтуань» (шударга энхийн бүлгэм) буюу «Ихэтуань» (шударга энхийн төлөө нударга) хэмээх нууц шашны нийгэмлэг удирдаж байв. «Ихэтуаний бүлгэм» нь Шаньдун, Жили мужууд дахь «Ихэцюань», «Шэньцюань», «Хунцюань», «Дадао» зэрэг нууц бүлгүүдийн төв болж байв. Ихэтуаньчууд цугларч тарни унших, даосын ёсны биеийн тамирын анхдагч дасгал сурах ажил явуулдаг байв. Тэд биеийн хүчний дасгал хийж, тарнийн хэдэн үг цээжилснээр суманд даагдахгүй үүрт мөнх болно гэж үздэг байв. Энэ нь шашны нөлөөгөөр ард түмнийг тэмцэлд зоригжуулах гэсэн арга байв. Ихэтуань нар гадаадынхныг шүүмжилсэн үлгэр домог зохиож байсан нь харийн дарлалын эсрэг тэдний ухуулгын нэг хэлбэр байв. Ихэтуаньчуудын эгнээ гол төлөв тариачид, гар урчууд, цэргүүд, завьчид, ажилгүйчүүд зэрэг нийгмийн янз бүрийн давхраанаас бүрэлдсэн байв. Гэвч тэд нийгмийн байдал, шашин шүтлэг харгалзалгүй гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэх нэгэн зорилготой байв. Тухайн үеийн Хятадын нийгмийн хоцрогдлоос болж ихэтуань нар европын соёл, техникийн хөгжлийн ололт амжилтыг үгүйсгэж, хятадын нутагт тэдний барьсан байшин барилга, зам гүүр, шугам сүлжээ, сүм дуганыг бүгдийг устгахыг зорьдог байв.

1898 оны дөрөвдүгээр сард Шаньдун, Жили мужуудын хил дээр гадаадынхныг эсэргүүцсэн хөдөлгөөнүүд удаа дараалан гарч байв. Энэ үеэс эхлэн Ихэтуаний бослого эхэлсэн гэж үзэж болно.² Оны эцэс гэхэд

¹История Китая с древнейших времен до наших дней, М., 1974. 217 дугаар тал.

²Калюжная Н. М., Зарождение и развитие движения ихэтуаней де выходаихэтуаней за пределы провинции Шаньдун, 1889—1900, М., 1964, 14—15 дугаар тал.

Шаньдун мужийн арав гаруй хошуунд 25 мянган ихэтуаньчуудыг хамарсан хөдөлгөөн гарчээ.

1899 онд германчууд Зяожоуг эзлэсэн явдлыг эсэргүүцсэн Зяожоу-Зинаний төмөр замын ажилчид бослого гаргажээ. Энэ бослого Ишуй, Зинань Пиньюань, Гаотан, Чипин зэрэг 20 гаруй хошууг хамарч, уг бослогод 45 мянган хүн оролцжээ. Босогчид хар лам нарын сүм дуган, орон сууцыг эвдэж, германы цэргүүдийн эсрэг дайрчээ. Гэвч Зяожоуг эзлэсэн германы цэргүүд бослогыг даржээ.

1899 оны 9-10 саруудад Пиньюань хошууны ард түмэн ихэтуань нартай хамтран хар лам нарын эсрэг босжээ. Бослого гарах үндсэн шалтгаан нь католиг шашинтан нар ургацын гачигдлыг ашиглан нутгийн ардуудад тариа будаа дамласан явдал байв. Ихэтуань нарыг чинээлэг тариачин Жу Хундэн, лам Ян Тянынунь нар удирджээ. Босогчид хар лам нар болон нутгийн баячууд, газрын эздийн эсрэг тэмцэж байв. 1899 оны арван нэгдүгээр сард бослогын удирдагчид мужийн цэргүүдэд баривчлагдан төдөлгүй бослого дарагджээ.

Шаньдун мужийн захирагчид ихэтуань нарт харилцан адилгүй хандаж байв. Зарим нь ихэтуань нарын гадаадын эсрэг чиглэсэн бослогыг дэмжиж тэднийг өөрсдийн эрх ашигт нийцүүлэх, мужийн цэргүүдтэй нийлүүлэн өөрсдийн хяналт удирдлаганд оруулахыг зорьж байв. Зарим түшмэдүүд ихэтуаний хөдөлгөөнийг өөрсдийн эсрэг чиглэсэн гэж үзэн хайр найргүй дарж байв. Шаньдунд гарсан ихэтуаний хөдөлгөөнийг дарах явдалд гадаадын гүрнүүдийн дэмжлэг хүлээсэн Юань Шикай гол үүрэг гүйцэтгэсэн юм. Юань Шикай Шаньдун мужийн захирагч болж улмаар 1899 оны арван хоёрдугаар сарын 27-нд «Ихэтуаний хөдөлгөөнийг дарах тушаал» гаргажээ. Шаньдун мужид гарсан ихэтуаний хөдөлгөөнийг дарахад гадаадын хүчтэй зэр зэвсгээр зэвсэглэсэн 7000 цэрэг оролцжээ.

Энэ үед Ихэтуаний цэргүүд Жили мужийн Учэн хошуу руу ухарч ихэтуаний гол хүч Шаньдунаас гарч Жили мужид төвлөрөх болжээ.

1899 оны намар Жили мужийн ихэтуаний хөдөлгөөн Шаньдун-Жилийн хил дээр гарчээ. 1899 оны Сүүлчээр Зинжоу хошуунд Сю У-гээр удирдуулсан ихэтуаний хөдөлгөөн нилээд газар авчээ. Босогчид христосын сүм дуган, католиг шашинтан хятадуудын гэр орныг шатаах зэргээр тэмцэл явуулж байв. Уг хөдөлгөөнийг мужийн цэргүүд, манжийн засгийн газрын цэргүүдтэй нэгдэн даржээ. Шаньдуны түшмэдүүдийг бодвол Жилийн түшмэдүүд түүний захирагч Юй Лу ихэтуань нартай хайр найргүй тэмцэж байв.

1900 оны гуравдугаар сард Шаньдуны ихэтуань нар Жилид орж ирсэн нь нутгийн ард түмэн болон ихэтуань нарыг бослогонд зоригжуулсан юм. Энэ үед ихэтуаний хөдөлгөөн хойд зүг рүү тархаж нэг хэсэг нь Тяньжин рүү, нөгөө хэсэг нь Бээжин рүү чиглэжээ. Мужийн захирагч Юй Лугийн цэргүүд ихэтуаний бослогыг дарахаар Тяньжинээс гарч тавдугаар сарын 13-наас 22-ны өдрүүдэд Лайшуй, Динсин хошуунд ихэтуань нартай тэмцэлдсэн боловч Лайшуй хошууны Шитин тосгонд ихэтуань нарт бүслэгджээ. Иймээс Юй Лу генерал Не Шичэнээр толгойлуулсан цэргүүдийг явуулж Баодинд байгаа ихэтуань нарыг дарахыг тушаажээ. Не Шичэний цэргүүд ихэтуаньчуудыг дарахаар Тяньжинээс гарсан боловч амжилт ололгүй Тяньжинд буцаж иржээ. Энэ үед ихэтуаний хөдөлгөөнд 100 мянга гаруй хүн хамрагджээ. Ихэтуаний гол хүч Бээжин, Тяньжины хавь газрууд Баодин, Тунжоу хошуунд бөөгнөрсөн байв. Тяньжины хавьд ихэтуаний хөдөлгөөнийг завьчин Жан Дэчэн, хуучин цэрэг байсан Цао Футянь, чинээлэг тариачин Хань Или, худалдаачны хүү Лю Шизю, завьчны охин ихэтуаний эмэгтэйчүүдийн бүлгийн удирдагч Хуан Лян нар удирдаж байв. Бээжин хавийн ихэтуаний

удирдагчийн нэг бол цэргийн дарга байсан Ли Лайжун байв. Гэвч ихэтуаньчууд нэгдсэн удирдлагагүй, хоорондоо холбоогүй өөрсдийн бүлгийн биеэ даасан байдлыг хэт эрхэмлэдэг байв.

Жили болон Шаньдун мужид гарсан ихэтуаний хөдөлгөөн нь гадаадын түрэмгийлэл, хар лам нарын эсрэг тэмцлээ явуулж байв. Тэд эхний үед Манж Чин гүрнийг дэмжиж байв.¹ Хятад нутгийн умард хэсэгт империалист түрэмгийллийн эсрэг ард түмний бослого хүчтэй өрнөж байх үед империалист гүрнүүд Манж Чин гүрний засгийн газраас босогчдыг дарахыг шаардаж байв. 1900 оны гуравдугаар сарын 10-нд гадаадын гүрнүүдийн дипломат төлөөлөгчид Бээжин дэх Зунли ямынь (ерөнхийлэн шийтгэх яам)-наас «Ихэтуаний бүлгэмийг» хорих тухай заалт гаргахыг шаарджээ. 1900 оны тавдугаар сарын 21-нд империалист гүрнүүд Манжийн засгийн газарт хамтарсан нот өгчээ. Уг нотонд ихэтуаний хөдөлгөөнийг дарахыг шаарджээ. Үүний хариуд Зунли ямынь Бээжин дахь дипломат корпосуудад ихэтуаний бослогыг дарахаа амлаж, Не Шичэний цэргийг дахин ихэтуаний бослогыг даруулахаар явуулжээ.

Тавдугаар сарын 2-нд Англи, Франц, Япон, Орос, Итали, Австр, Венгр, АНУ-ын төлөөлөгчид Жилийн буланд байрласан гадаадын цэргүүдээс Бээжинд улс тус бүрээс 50-100 цэрэг оруулахаар тохирчээ. Тавдугаар сарын 30-нд Дагуд гадаадын 15 усан онгоц ирж, түүнээс хоёр хоногийн дараа 8 орны десантууд боомтын эргээр байрласан байв. Бээжинд гадаадынхны 387 хүнтэй, Тяньжинд 310 хүнтэй цэргийн ангиуд байрласан байв. Энэ нь империалист улсуудаас Манж гүрний ноёрхолд байсан хятад орныг зэвсгийн хүчээр хуваан эзлэх түрэмгийллийн эхлэл нь болсон юм.

1900 оны зургадугаар сарын 10-нд гадаадын дипломатууд манжийн засгийн газарт «өөрийн орны хүнийг бүхий л аргаар хамгаалах эрхтэй» хэмээн мэдэгдэв. Мөн өдөр английн жанжин Сеймураар толгойлуулсан 2000 гаруй гадаадын цэргүүдийн нэгдсэн бүлэг Тяньжинээс Бээжингийн чиглэлд хөдлөв.² 1900 оны зургадугаар сарын 17-нд гадаадын цэргүүд Дагуг эзлэн авч зургадугаар сарын 21-нд тэндээсээ Тяньжинь рүү хөдөлжээ. Дагугийн цэргийн цайзыг эзлэн авснаар империалист гүрнүүд хятадын эсрэг дайныг зарлалгүй эхлэв.

Энэ үед Манжийн засгийн газар ихэтуанийхан болон гадаадын түрэмгийлэгчдэд хоёр нүүр гаргаж байв. Манж гүрний засаг төрийн удирдлагын дотор хоёр бүлгийн хурц тэмцэл явагдаж байв. Нэг хэсэг манж, хятад язгууртан, түшмэдийн төлөөлөгчид нь гадаадын түрэмгийлэгчдийн эррэг тэмцэж ихэтуаний тэмцлийг дэмжихийг Манжийн хатан хаан «төр хамаарагч»-Цыси (Си тайхоу)-д зөвлөж байв. Тэдний төлөөлөгчид нь Дуйнь, Ган И нар байв. Нөгөө хэсэг феодалууд нь гадаадын гүрнүүдтэй харилцаагаа муутгахгүйг хичээн ихэтуаний бослогын эсрэг зогсож байв. Ийм үзэл баримтлагчид нь Юань Чан, Сюй Зинчэн, Сюй Юни зэрэг түшмэлүүд байжээ. Цысигээр толгойлуулсан манжийн төрийн бүлэг ихэтуань нарын империалист түрэмгийллийн эсрэг тэмцлийг дэмжсэн атлаа тэднээс нутгийн феодалуудын эсрэг хийж байсан тэмцлийг эрс эсэргүүцэж байв. Энэ нь Манжийн засаг төрийг сахин хамгаалах зорилготой байв. Бээжингийн зүгрүү хөдөлсөн ихэтуань нар Лофа станцад Сеймурын цэрэгтэй тулалдаж амжилт олоод зургадугаар сарын 13-нд Бээжинд орж иржээ. Тэд Бээжинд орж ирсэн үеэсээ эхлэн байшин барилга галдан шатааж, манжийн язгууртнуудын гэр орон, эд хогшлыг эвдэн сүйтгэж байв. Ихэтуаньчууд хааны ордны дотор орж, ихэмсэг түшмэдүүдийг айлган сүрдүүлж байв.

¹Новая история Кигая, М., 1972. 13 дугаар тал.

²Калюжная Н. М. Восстание ихэтуаней (1894—1901) М., 1973, 10 дугаар тал

Манжийн Бадаргуулт төр хаан зургадугаар сарын 14-нд «гол гэмт хэрэгтнүүдийг баривчилж, хүнд шийтгэл ноогдуулж, тэдний хамсаатнуудыг хөөн тараах тухай зарлиг» гаргасан байна.¹ Энэ үеэс эхлэн манжийн засгийн газар засаг төрөө алдахаас айн улмаар ихэтуаний эсрэг хайр найргүй тэмцэгч Юань Шикай болон улс төрийн нэрт зүтгэлтэн Ли Хунжаныг Бээжинд дуудан ирүүлэв.

Нэгэнт империалист гүрнүүд Дагуг дайрч түрэмгийллээ эхэлсэн учир зургадугаар сарын 21-нд манж гүрний засгийн газар гадаадын гүрнүүдэд дайн зарлажээ. Энэ үед манжийн засгийн газар ихэтуаний хөдөлгөөнийг ашиглах зорилгоор тэднийг дэмжин урамшуулах тушаал гаргав. Манж нар ихэтуаний хөдөлгөөнийг өөрийн эсрэг чиглүүлэхгүйн тулд түүнийг хяналтандаа авч, тэдний нэгдсэн удирдлагагүйг ашиглан удирдагчаар нь тайж Жуан, хааны ордны шадар түшмэдүүдийн толгойлогч Ган И нарыг томилжээ. Манжийн засгийн газар империализмын эсрэг ихэтуаний бослогыг дэмжээд ирэхийн хамт өргөн олон ард түмэн уг тэмцэлд нэгдэн босч улмаар энэ тэмцэл Шаньси, Жэзян, Фузянь, Хубэй, Хунань, Сычуань, Юньнань, Зүүн хойд хятадын нутгийг хамрав.

Энэ үед босогчид «Манж Чин гүрнийг дэмжье, гадаадынхныг сөнөөе* гэсэн уриаг баримталж байв. Энэ үед ихэтуань нар Шаньдун мужид католиг шашинтны 70 гаруй сүм дуган эвдэн сүйтгэж 150 гаруй гадаадынхныг алсан байна. Зүүн хойд хятадын нутагт 1000 гаруй км төмөр замыг эвдэн сүйтгэжээ. Мужийн зарим түшмэд ихэтуаний бослогыг дэмжиж байсны дотор Шаньси мужийн захирагч Юй Сянь байв.

Зүүн ба Өмнөд хятадын түшмэдүүд Ли Хунжан, Лю Кунь, Жан Жидун, төмөр замын ерөнхий байцаагч Цэнь Сюаньхуай зэрэг гадаадын империалистүүдтэй нягт холбоо тогтоож, ихэтуаний хөдөлгөөнийг дарахыг манжийн засгийн газарт ятгаж, гадаадынхныг эсэргүүцсэн ард түмний аливаа тэмцлийг нухчин дарж байв. Түүгээр ч үл барам манжийн засгийн газраас гадаадынхны эсрэг зарласан дайныг үл тоомсорлон, зургадугаар сарын 26-нд гадаадын консулуудтай нууц хэлэлцээ байгуулж, тэдэнтэй хамтран ихэтуаний эсрэг тэмцэхээр тохиролцжээ. Мөн «Зүүн, өмнөд мужуудыг хамтран хамгаалах дүрэм» гэгчийг зохиож уг дүрмийг Фузянь, Жэзян мужийн сайд Сюй Инкуй, Жэзян мужийн захирагч Лю Шутан, Шаньдун мужийн захирагч Юань Шикай нар бүрэн дүүрэн хүлээн авчээ.

Хятадын феодал хөрөнгөтний төлөөлөгчид ихэтуаний бослогыг дэмжсэнгүй, Ихэтуань нар хятадын ард түмний дэвшилтэд хөдөлгөөний зандалчин, хуучныг баримтлагч манжийн засгийн газартай холбоо тогтоосон хийгээд, шашинг дээд хэмжээгээр эрхэмлэн, гадаадын соёлыг үзэн ядаж байсан нь хувьсгалт ардчилсан үзэлтнүүд, реформаторуудыг ихэтуань нараас хөндийрүүлж байв.²

Дагуд байрласан гадаадынхны цэрэг долдугаар сарын 14-нд Тянь жинг бүрэн эзлэж 1900 оны наймдугаар сарын 3-нд гадаадын 8 орны хамтарсан 20 мянга гаруй хүнээс бүрэлдсэн арми нийслэл рүү дайрав. Ихэтуань нар болон манжийн цэргүүд нийслэлийг хамгаалж удтал тэмцсэн боловч гадаадын цэргүүдийн зэвсгийн давуу талын улмаас ялагдаж наймдугаар сарын 14-нд гадаадын түрэмгийлэгчид нийслэлийг эзлэн авав.

Тэднийг Бээжинд орж ирэхийн хамт манжийн хаан Сиань руу зугтжээ. Манжийн хаан империализмын хүчний давуу талыг мэдмэгц засгийн цэргүүдэд ихэтуань нарын эсрэг дайтах хэд хэдэн тушаал гаргажээ. Энэ үеэс манжийн засгийн газар ихэтуань нараас холбоогоо тасалж, харин манжийн цэргийн удирдагчид ихэтуань нарыг баривчлан алан

¹Восстания ихэтуаней, Документы и материалы, М., 1968, 110 дугаар тал.

²Калужная М. Н. Восстание ихэтуаней, (1898—1901), М., 1973, 12 дугаар тал

хядаж байв. Энэ нь Манж нараас засгийн эрхээ алдахгүй байх гэсэн ноёлогч ангийн хуурамч урвамтгай төрх шинжийг илтгэн харуулжээ. Манжийн засгийн газар гадаадын империалист гүрнүүдэд буулт хийж улмаар ихэтуань нарын хөдөлгөөнийг хайр найргүй дарж эхлэв. Энэ үед ихэтуаньчуудын бүлгээс ноёлогч ангийн төлөөлөгчид гарч, гагцхүү хөдөлмөрчин ардууд, тариачид үлдэв. Гэвч тэд 1901 оны гуравдугаар сар хүртэл хятадын зүүн хойд нутагт тэмцлээ үргэлжлүүлсээр байв.¹

Манжийн засгийн газар гадаадынхны түрэмгийлэл эхлэх үед арга буюу тэдэнд дайн зарлаж ихэтуаний тэмцлийг өөрийн эрх ашигт тохируулан ашиглахын тулд тэднийг дэмжиж байсан боловч, империалистуудын цэргийн зэвсэг хүчийг давж чадахгүйгээ мэдмэгц, зөвхөн ноёлогч ангийн эрх ашгийг хамгаалж, гадаадын эзлэн түрэмгийлэгчдэд буулт хийж, тэдэнтэй хамтран ихэтуаний бослогыг хайр найргүй дарсан юм.

1901 оны есдүгээр сарын 7-нд Ли Хунжан манжийн засгийн газрын нэрийн өмнөөс гадаадын найман гүрэнтэй Синьчоугийн гэрээ (1901 оны) буюу «төгсгөлийн тэмдэглэл» гэгчид гарын үсэг зурсан нь хятадыг хагас колонийн орон болгохыг улам бататгасан юм. Энэ гэрээгээр Манжийн засгийн газар гадаадын гүрнүүдэд 39 жилийн дотор 430 сая лан мөнгөөр дайны төлбөр төлөхөөр тохиролцжээ.² Уг гэрээгээр Манжийн засгийн газар хятадын ард түмний гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг тэмцлийг бүрмөсөн зогсоох талаар баталгаа гаргаж, Дагугийн цайзыг нурааж, империалист улсуудын цэргүүдийг Бээжин, Тяньжин Шанхайгуаний төмөр замын шугамын дагуу гол районуудад байрлуулах болов. Мөн Бээжин дахь Дунцяоминсян районыг «элчин сайдын яамны район» болгож түүнийг гадаадын цэргүүдээр хамгаалуулахыг зөвшөөрч, хятад оршин суугчдыг уг районд суухыг хориглов.³ Ийнхүү Манжийн засгийн газар империалист гүрнүүдтэй 1901 оны «төгсгөлийн тэмдэглэл» гэрээ байгуулсан нь империалист гүрнүүдийн зүгээс Хятад орныг колоничлох явдлыг улам идэвхжүүлэв. Энэ тухай хятадын түүхч Фань Вэнь-лань «төгсгөлийн тэмдэглэл» гэрээ байгуулснаар Хятад улс бүрмөсөн хагас колонийн орон боллоо»⁴ гэж бичсэн нь Манж гүрний ноёрхолд байсан хятад орон гадаадын империалистуудын хагас колони болон хувирсныг тэмдэглэн хэлсэн бололтой.

1902 онд Манжийн засгийн газар Бээжинд буцаж ирсэн боловч гадаадын гүрнүүдийн дуулгавартай зарц нь болж байв.

Манж гүрний ноёрхолд 200 гаруй жил нухлагдсан хятадын ард түмний энэхүү эх оронч шударга тэмцлийг тухайн үеийн олон улсын ажилчны хөдөлгөөн дэмжиж байв. Дэлхийн пролетари нарын аугаа их жолоодогч В. И. Ленин хятадын ард түмэн өрнөдийн империалистуудын эсрэг босох болсон шалтгааныг тодорхойлохдоо: «Зөвхөн баяжихын төлөө хятадад ирдэг, зөвхөн хуурч мэхлэх, дээрэмдэх, хүчирхэхийн тулд гайхуулж магтдаг соёлоо ашигладаг, ард түмнийг мунхруулагч хар тамхи худалдах эрх олж авахын тулд Хятадтай дайн хийдэг, дээрмийн бодлогыг христосын шашин дэлгэрүүлэх явдлаар нууцлан бүрхэгдүүлдэг хүмүүсийг хятадууд хорсон үзэн ядахгүй байх болох байсан уу?»⁵ гэж хэлсэн байна. Энэ нь гадаадын империалист улсуудаас манжийн ноёрхолд байсан Хятад оронд явуулсан түрэмгий бодлогын мөн чанарыг онож хэлсэн дүгнэлт даруй мөн ажээ.

¹Новая история Китая, М., 1972, 358 дугаар тал.

²История Китая с древнейших времен до наших дней, М. 1974, 230 дугаар тал

³Лиши фусюэ цанкао зыляо, (Түүхийн хичээлийг давтахад зориулсан материал) Бээжин, 1980, 96 дугаар тал.

⁴Фань Вэньлань, Новая история Китая, М., 1955, 573 дугаар тал.

⁵В. И. Ленин, зохиолууд, IV боть, 372 дугаар тал.

«Ихэтуаний бослого» хэмээн түүхэнд алдаршсан хятадын ард түмний империализмын эсрэг шударга тэмцлийн түүхэн хуудас хятадын түүхэнд мөнх үлдэх ёстой. Гэтэл одоогийн Бээжингийн эрх баригчдын улс төрийн чиг шугамаас болж маоист түүхчид ард түмний энэхүү тэмцлийн түүхийг гуйвуулж байгаа нь империализмыг тэтгэн дэмжиж буй Бээжингийнхний бодлоготой холбоотой юм.

Одоогийн хятадын маоист түүхчид Ихэтуаний хөдөлгөөнийг судлахдаа империализмын эрх ашигт аль болох тохируулан, тэдний тухайн үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлийг товойлгон үнэлж, эзлэн түрэмгийлэх үйл ажиллагааг нь бүрхэгдүүлж байна. (Жишээлбэл: Хятадын түүх судлаач Ли Кань «Ихэтуаний хөдөлгөөнийг үнэлэх тухай асуудлууд» хэмээх өгүүлэлдээ: Ихэтуань нар «империализмын үйлдвэрлэлийн арга, шинэ үеийн шинжлэх ухаан-техникийг дорд үзэж байсан нь зөвхөн хувьсгал бишээр барахгүй, түүхийн хөгжлийг хойш нь татаж, түүнийг хойш нь ухраасан юм»¹ гэжээ. Өгүүллийг зохиогч энэхүү ихэтуаний хөдөлгөөн түүхийн хөгжлийг хойш нь ухраасан хэмээн дүгнэхдээ тухайн үеийн империалист түрэмгийлэл Хятадыг хуваан авч, хагас колонийн байдалд оруулсан хийгээд, түүнээс хятадын ард түмэн, нийгмийн хөгжилд учруулсан хор хөнөөлийг зориуд дурдахгүй байгаа нь гайхалтай биш юм.

Манж гүрний төрд зарцлагдан үйлчилж, хятадын ард түмний эрх ашгаас урвасан хятадын феодал ангийн төлөөлөгчид тухайн үед империализмын дуулгавартай зарц болж ард түмнийхээ гадаадын түрэмгийллийн эсрэг тэмцлийг цус асгаруулан даралцаж улмаар хятад орноо хагас колонийн орон болгон хувиргасан нь хятадын түүхийн хуудаснаа гашуун сургамж болон үлдсэн нь нэн тодорхой билээ.

ВОССТАНИЕ ИХЭТУАНЕЙ (1898-1901)

(к 80-летию)

(Резюме)

Н. Алтанцэцэг

Восстание ихэтуаней, вспыхнувшее на рубеже XIX-XX веков и охватившее обширную территорию Северного и Северо-Восточного Китая, отличается от других крестьянских восстаний тем, что его острие было направлено против империалистической агрессии.

Прогнившее маньчжурское правительство было не в состоянии остановить агрессию империалистических держав в Китае. Помимо этого, Японо-Китайская война, в результате которой Япония одержала победу над Китаем; еще более ускорила вторжение империалистических держав. Агрессивные действия империалистических стран проявлялись не только в области политики, экономики, но и в идеологии, носителями которой являлись католические миссионеры.

Крестьяне несли на себе бремя дополнительных налогов, страдали от спекуляции землей и зерном. Ремесленники лишались заработка из-за проникновения дешевых иностранных товаров. Поэтому среди недовольных масс различных общественных слоев, ихэтуани, в состав которых вош-

¹«Жэньминь жибао», 1980. IV 10.

ли крестьяне, ремесленники, солдаты, лодочники и шэньши, вели наиболее устойчивую борьбу против иностранной агрессии.

Антиимпериалистический характер восстания ихэтуаней проявлялся в борьбе с иностранными миссионерами, в забастовках на иностранных предприятиях и в прямом столкновении с иностранными войсками. Главным лозунгом повстанцев было «уничтожение и изгнание иностранцев из Китая».

В организационном отношении ихэтуани разделялись на отряды, каждый из которых имел свой флаг. Хотя отсутствовали единое руководство, четкая программа борьбы, повстанцы выступили на борьбу как против местных феодалов, так и против маньчжурских аристократов.

Цинские правители, представлявшие класс угнетателей, использовали повстанцев для своих корыстных целей, однако, после капитуляции цинского правительства маньчжурские войска вместе с войсками интервентов стали беспощадно подавлять восстание ихэтуаней.

Заключительный протокол, подписанный между цинским правительством, и империалистическими державами 7 сентября 1901 года, закрепил полуколониальное положение Китая. Хотя народное восстание Северного Китая, вошедшее в историю под названием «восстания ихэтуаней», было подавлено иностранными интервентами и маньчжурскими войсками, оно сорвало планы империалистических держав по окончательному расчленению Китая.

Современные китайские историки в соответствии с внешней политикой нынешних китайских лидеров искажают историю и значение восстания ихэтуаней. Главное внимание они уделяют научно-техническому превосходству империалистических держав того времени, но умалчивают о пагубных последствиях их колониальной политики для Китая и китайского народа.